



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/396

Ховд

Газар албадан чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "н", 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.4 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Буянт багт ундны усны хамгаалалтын бүсэд зөвшөөрөлгүйгээр газрыг дур мэдэн эзэмшсэн, хашаа барьсан, шон суулгасан газрыг албадан буулгаж, чөлөөлсүгэй.

2. Газар албадан чөлөөлөх арга хэмжээний зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулахыг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/-д даалгасугай.

3. Газар чөлөөлүүлэх, албадан нүүлгэхэд хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн бол зохих журмын дагуу арга хэмжээ авч, нийгмийн хэв журмыг сахиулахыг Цагдаагийн газар /Б.Даваасүрэн/-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг 7 дугаар сарын 27-ны дотор хангаж, Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН